

Боловсролын ач холбогдол

Дараах судрууд болон Сүмийн удирдагчдын хэлсэн үгс боловсрол эзэмшихийг танаас хүсдэг Их Эзэний хүлээлтийг илүү сайн ойлгоход тань туслах болно. Суралцах явцдаа боловсролын ач холбогдлын талаарх үнэнийг олж мэд.

Судлах судар:

Сургаал ба Гэрээнүүд 88:77–80, 118; 130:18–19

Сүмийн удирдагчдын зааврууд:

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон ийн заасан.



Боловсрол бол таны олж эзэмших зүйл юм. Хэн ч таны өмнөөс үүнийг эзэмшиж чадахгүй. Та нар хаана ч байлаа гэсэн суралцах маш их хүсэлтэй бай. Хожмын үеийн гэгээнтэн бидний хувьд боловсрол олж авах нь зөвхөн онцгой эрх биш юм, энэ бол шашны үүрэг хариуцлага билээ. “Бурханы алдар суу бол оюун билиг юм” (Сургаал ба Гэрээнүүд 93:36). Үнэндээ, бидний боловсрол бол үүрд мөнхөд үргэлжлэх зүйл билээ. . . .

Иймэрхүү алсын хараатай ойлголт нь суралцах талаар сайн сонголт хийхэд тань туслах болно.

Ах, эгч нар аа, зорилгодоо—тэр бүү хэл мөрөөдөлдөө хүрэхээр хичээхээсээ бүү ай! Аливаа зүйлийг хамгийн сайн, бүрэн гүйцэд хийж сурахад амар дөт зам гэж байдаггүй. Боловсролтой болох нь бусад хүнд туслахыг хүсэх болон тэдэнд туслах боломжтой байх хоёрыг ялгаатай болгодог юм. (Рассэлл М.Нэлсон, “Та нар юуг сонгох вэ?” Ensign, 2015 оны 1-р сар, 32)

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднар ийн хэлсэн.



Бид энэ дэлхийд мөнх амьдралд бэлдэхээр, хэрхэн суралцах талаар судлахаар, зуурдын амьдралд чухал болон мөнх амьдралд зайлшгүй шаардлагатай зүйлсийн талаар судлахаар мөн бусдад мэргэн ухаан хийгээд үнэний талаар сурч мэдэхэд нь туслахаар ирсэн болно (Сургаал ба Гэрээнүүд 97:1-ийг үзнэ үү). Бид хэн бэ, хаанаас ирсэн бэ, яагаад дэлхий дээр оршин байгаа вэ гэдгийг ойлгосноор бидний хүн нэг бүрд хэрхэн суралцах мөн суралцахуйн үнэ цэнийг ойлгох асар их үүрэг хариуцлага оногддог. (Дэвид А.Бэднар, “Learning to Love Learning,” Ensign, 2010 оны 2-р сар, 27)

Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч Камилл Н.Жонсон ийн хуваалцсан.



Бид боломжоороо аль болох боловсрол олж авч, сургалтад хамрагдсанаар бэлтгэлтэй байж чадна. Энэ нь дэлхийд болон Сүмд үйлчлэхэд бэлэн байхын тулд юм. Мөн хань ижлийнхээ ухаалаг зөвлөгч, хамтрагч болоход бэлэн байхын тулд, биднээс үлгэрлэдэг хүүхэд, залуучуудад үр нөлөөтэй багш болоход бэлтгэлтэй байхын тулд юм. Ихийг сурах тусам бид сайн сайхны төлөө илүү их нөлөө үзүүлж чадна.” (Камилл Н.Жонсон, “Seek Learning by Study and by Faith” [BYU-Pathway Дэлхий даяарх онцгой цугларалт, 2021 оны 10-р сарын 19], byupathway.org).

Өсвөр үеийнхний бат бөх байдлын төлөө: Сонголт хийхэд туслах хөтөч:

Тэнгэрлэг Эцэг охид, хөвгүүдээ үргэлж суралцдаг байгаасай гэж хүсдэг. Танд суралцахыг эрэлхийлж, суралцахад дурлах материаллаг, сүнслэг шалтгаан аль аль нь бий. Боловсрол бол зөвхөн мөнгө олох тухай асуудал биш. Энэ бол Тэнгэрлэг Эцэгтэйгээ илүү адилхан болох мөнхийн зорилгын тань нэг хэсэг юм. . . .

Оюун ухаанаа тэлж, ур чадвараа сайжруулах боломжийг эрэлхийл. Энэ боломж нь сургууль, мэргэжил сургалтын төвөөс авч болох албан ёсны боловсролоос гадна өөрийн найдвартай гэж үзсэн боловсролын албан бус эх үүсвэрүүд байж болно. Хичээл зүтгэлдээ Их Эзэнийг оролцуулснаар Тэр таныг удирдах болно. Амьдарч буй эх дэлхийнхээ талаар суралцахдаа дэлхийг бүтээсэн Есүс Христийн талаар түүнчлэн суралц. Түүний амьдрал, сургаалаас суралц. Институт, семинар, сайн мэдээнээс суралцах хувийн сургалтаа насан туршид суралцах үйл явцынхаа нэг хэсэг болго. (Өсвөр үеийнхний бат бөх байдлын төлөө: Сонголт хийхэд туслах хөтөч [2022], 31)